



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/492

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.12, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Санхүү,төрийн сангийн хэлтсээс аймгийн төсвийн 2020 оны төсөл, 2021-2022 оны дунд хугацааны төсвийн төсөөллийг Сангийн яаманд хүргэж хянуулах, нутгийн брэнд бүтээгдэхүүнийг сурталчлах арга хэмжээний зардалд ажиллах багийн үйл ажиллагаанд зарцуулах 6000,0 мянган төгрөг /Зургаан сая/ -ийн төсвийг хавсралтаар баталж зарцуулсугай.


2.Үйл ажиллагаанд зарцуулах 6,0 сая төгрөгийг аймгийн хөрөнгө оруулалтын захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ



№/Zax/A/492-᠑᠗1

Аймгийн Засаг даргын 2019 оны 07 дугаар
сарын 30-ны өдрийн А/492 дугаар
захирамжийн хавсралт



АЙМГИЙН 2020 ОНЫ ТӨСӨВ, 2021-2022 ОНЫ ТӨСВИЙН
ТӨСӨӨЛӨЛ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ
ХЯНУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ

| Д/д | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Тоо | Нэг бүрийн үнэ /төгрөг/ | Нийт үнэ /төгрөг/ |
|-----|--|----------------|-----|----------------------------|----------------------|
| 1 | Ховд аймгаас Улаанбаатар хот, Улаанбаатар хотоос Ховд аймаг орох хот дотор шатахууны үнэд /1700 км*2*0.20/ | ширхэг | 680 | 2500 | 1700000 |
| 2 | Улаанбаатараас Ховд орох ачааны үнэд | кг | 800 | 450 | 360000 |
| 3 | Барааны үнэ /Шийгуа, жимс, жимсгэнэ/ | кг | 750 | 2800 | 3100000 |
| 4 | Ховдын брэнд бүтээгдэхүүн | ш | 50 | 8500 | 425000 |
| 5 | Бусад ажил үйлчилгээ | | | | 415000 |
| | Дүн | | | | 6 000 000 |

-oOo-